

Б.Энхбаяр:шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад хонги­лыг нураах зарчмыг баримталж ажилласан

УИХ-ын гишүүн Б.Энхбаяр Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг танилцууллаа.

Ажлын хэсэг нийт 6 удаагийн олон нийтийн хэлэлцүүлгийг хийснээс гадна шүүгч нарын төлөөллөөс холбогдох санал дүгнэлтийг авчээ. Ажлын хэсэг нийтдээ 28 удаа хуралдсан бөгөөд зарчмын зөрүүтэй 75 саналыг бэлтгэжээ.

УИХ-ын гишүүн Б.Энхбаяр “Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд ажлын хэсэг дараахь үндсэн зарчмуудыг баримталж ажилласан:

- Нэгдүгээрт, Монгол Улсын Үндсэн хууль, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт, түүний үзэл баримтлалыг хатуу чанд мөрдөх
- Хоёрдугаарт, олон улсын дэвшилтэт чиг хандлагыг нутагшуулах
- Гуравдугаарт, нэгэнт тогтсон буруу практик буюу хонги­лыг нураах
- Дөрөвдүгээрт, хэн ч шүүх эрх мэдлийн системд дураар халдах, дангаар дарга болж засаглах боломжгүй шударга ёсны зарчмыг бэхжүүлэх зарчмыг баримталсан.
-

Дээрх дөрвөн зарчмаар дамжуулж дараахь үндсэн 4 үр дүнд хүрнэ:

- Монгол Улсын иргэд шударга шүүхээр шүүлгэх, эрхээ хамгаалуулна
- Бие даасан шүүх эрх мэдлийн хараат бус байдал хангагдана
- Хамгийн шилэгдсэн буюу хамгийн сайн нь шүүгч болдог тогтолцоог бий болгоно
- Шүүгчийн мэргэжлийн, сахилгын хариуцлагын тогтолцоо амилна” гэв.